



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/41

Чингис хот

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1, аймгийн Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 10.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хаврын улиралд үүсч болзошгүй махны хомсдол, үнийн хэт өсөлтөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зах зээлд хямд өртөгөөр борлуулах 33.4 тн нөөцөлсөн махны нэр төрөл, тоо хэмжээ, хадгалалт, тээвэрлэлт, ангилан савлалт, борлуулалтад хяналт тавьж ажиллах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Мөнхжаргал	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Г.Баттуяа	Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн
Гишүүд:	Б.Оргодол	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
	Т.Баяртуяа	Аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав

2. Дээрх ажлыг аймгийн Засаг даргын баталсан ТА-2020/01 дугаартай гэрээнд заасан нөхцөл, шаардлагын дагуу зохион байгуулж, акт үйлдэн холбогдох баримтыг бүрдүүлж, тайлагнаж ажиллахыг комиссын дарга /Б.Мөнхжаргал/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030217